



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

0018 оны 10 сарын 03 одөр

Дугаар 9/24

Мандалговь

Г

"Нэг суурин-Нэг бахархал" аян  
зохион байгуулах тухай

Монгол улсын Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.48.12, 2.52.3 дахь заалт, ХХААХҮЯМНЫ ТӨРИЙН БИЧГИЙН ДАРГЫН 2018 ОНЫ А/453 ТУШААЛЫГ ТУС ТУС ҮНДЭСЛЭН ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Орон нутгийн түүхий эд, неөөц баялагийг ашиглан брэнд бүтээгдэхүүнийг илрүүлэх, бий болгох, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ зрхлагчдийн, үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүнийг зах зээлд түгээн дэлгэрүүлэх, шинэ зах зээл, шинэ түншлэл бүхий олон талт хамтын ажиллагаат хөгжүүлэх, импорт орлохуйц бүтээгдэхүүн, экспортын барааны нэр төрлийг олшируулах, өрсөлдөх чадварыг бий болгох, хүн амыг эрүүл аюулгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах зорилгын хүрээнд "Нэг суурин-Нэг бахархал" аяныг 2018 оны 12 дугаар сараас 01-ний өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаатай аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

Хоёр. Аяныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүд: Д.Энхтуяа (Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Б.Мөнхжаргал (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Ням (MXAYT-ын Дундговь салбарын дарга)

Д.Чандмань (Дундговь аймгийн ХАХХолбооны дарга)

Ж.Зоригтбаатар (АОЭХ-ны Дундговь салбарын тэргүүн)

Нарийн бичгийн дарга: Ж.Мөнхбаяр (ХХААГ-ын мэргэжилтэн)

Гурав. Аяныг удирдамжийн дагуу зохион байгуулан, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тайллагнаж ажиллахыг ажлын хэсэг /Н.Эрдэнэ-Очир/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488010621

